

# УЛС ОРНУУДЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ТАНИЛЦУУЛАХ АРГА АРГА ЗҮЙ БА ТУРШЛАГА /ЛАВЛАГАА/

## Япон Улсын шүүхийн шийдвэр танилцуулах туршлага<sup>1</sup>

**Нэг. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 22.10 дахь хэсгийн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэхэд авч үзэж болохуйц туршлага**

Тус улсад олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор шүүхийн шийдвэрийг ойлгомжтой байдлаар танилцуулахад баримтлах тогтсон дүрэм журам, арга зүй, заавар гэж батлагдаагүй бөгөөд тухайн шүүх бүрийн Олон нийттэй харилцах хэлтэс нь тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч болон шүүх бүрэлдэхүүнтэй хамтран шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтанд хүргүүлдэг.

Ингэхдээ тус улсын Дээд шүүхийн ажлын албаны Олон нийттэй харилцах хэлтсээс гаргасан Олон нийттэй харилцах гарын авлагад дурдсан дараах зөвлөмжийг баримталдаг байна.<sup>2</sup>

### 1.1. Шүүхийн шийдвэрийн хураангуйг танилцуулахын ач холбогдол

Шүүхийн шийдвэрийг танилцуулахын өмнө сэтгүүлчдээс Олон нийттэй харилцах хэлтэст хандаж, шүүхийн шийдвэрийг танилцуулсны дараа шүүхийн шийдвэрийн хураангуйг тарааж өгөхийг хүсдэг. Энэ нь сэтгүүлчид шүүхийн шийдвэрийг танилцуулсны дараа маш богино хугацаанд хэвлэлийн мэдээ бэлтгэх шаардлагатай байдагтай нь холбоотой бөгөөд энэ богино хугацаанд тухайн шүүхийн шийдвэрийг бүрэн уншиж танилцах, эсхүл шүүхийн шийдвэрийн үндэслэлийг танилцуулж буй хэсгийг сонсоод тухайн шүүхийн шийдвэрийн гол чухал хэсгийг барьж авч ойлгох нь их хүндрэлтэй байдаг. Иймд шүүхийн шийдвэрийн талаар үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэхийн тулд шүүхийн зүгээс шүүхийн шийдвэрийн хураангуй, гол санааг бэлтгэж, тараах нь үр дүнтэй гэж үзэж, энэхүү ажлыг байнга хийсээр ирсэн юм.

### 1.2. Шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэхэд туслалцаа авах

Шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэх нь Олон нийттэй харилцах хэлтсийн чиг үүрэг боловч тус хэлтэс нь тухайн хэрэг болон шүүхийн шийдвэрийн агуулгын талаар нарийн мэдэх шүүгч болон шүүх бүрэлдэхүүний туслалцааг авах зайлшгүй шаардлага тулгардаг. Практикт тухайн хэргийн шүүхийн шийдвэрийг үнэн зөв, бодитоор олон нийтэд мэдээлэхийн тулд сэтгүүлчдээс шүүхийн шийдвэрийн хураангуйг хүссэн тохиолдолд Олон нийттэй харилцах хэлтсийн ажилтан нэн даруй шүүгч болон шүүх бүрэлдэхүүнтэй холбогдож, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэж өгөхийг хүсдэг.

Шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэхдээ дараах зүйлсэд анхаарлаа хандуулах шаардлагатай.

1. Хэт урт нуршуу, дэлгэрэнгүй биш байхад анхаарах

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа өдөр тутмын сонинд шүүхийн шийдвэрийн агуулгыг нийтлэхэд хуудасны хязгаар байдаг тул хэт урт нуршуу шүүхийн шийдвэрийн

<sup>1</sup> Боловсруулсан Б.Хонгорзул (LL.M)

<sup>2</sup> Тус улсын Дээд шүүхийн Олон нийттэй харилцах хэлтсээс 2020 оны 3-р сард гаргасан “Олон нийттэй харилцах гарын авлага”-ын 55-56 дахь талаас орчуулан хүргэв.

хураангуй бэлтгэсэн тохиолдолд зарим хэсгийг хасаж, нийтлэх шаардлага гардаг. Иймд тухайн хэргийн онцлогоос шалтгаалах боловч өдөр тутмын сонинд нийтлэх шүүхийн шийдвэрийн хураангуйн хувьд хамгийн уртдаа 3000 тэмдэгт, шүүхийн шийдвэрийн гол агуулга, чухал хэсгийг 300 тэмдэгт орчимд багтаасан байх нь зохимжтой.

## 2. Ойлгоход хялбар байхад анхаарах

Тухайлбал олон хэргийн оролцогчтой иргэний хэргийн хувьд сэтгүүлч шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг уншсан ч шүүхийн шийдвэрээр хүлээн зөвшөөрсөн мөнгө дүнг олж мэдэх боломжгүй байх тохиолдол бий. Иймд шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэхдээ шүүхийн шийдвэрээр хүлээн зөвшөөрсөн мөнгөн дүнг бичих нь буруу мэдээлэл түгэхээс сэргийлдэг. Олон хэргийн оролцогчтой гэм хорын хохирол шаардсан хэргийн хувьд шүүхийн шийдвэрээр хүлээн зөвшөөрсөн мөнгөн дүн, шүүхийн шийдвэр гарах үед нэхэмжлэгч нарын хүлээн зөвшөөрсөн мөнгөн дүнгийн дээд болон доод хэмжээ зэргийг шууд хараад ойлгохоор хүснэгтэн хэлбэрээр илэрхийлэх зэрэг арга хэрэглэх нь зохимжтой. Мөн шүүхийн шийдвэрийн хураангуйн дэд хэсэг бүрт гарчиг өгөх нь тухайн хураангуйн агуулгыг бүхэлд нь ойлгоход тустай байдаг. Шүүхийн шийдвэрийн хураангуй нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зориулсан бөгөөд шүүхийн шийдвэрийн эмхэтгэлд нийтлэх зориулалтгүй байдаг. Иймд эрх зүйн онолын чухал асуудал байлаа ч сэтгүүлчдийн зүгээс сонирхох асуудал биш бол тухайн хэсгийг хасаж, шүүхийн шийдвэрийн хураангуйг ердийн хүмүүс уншиж танилцахыг бодолцож, ойлгоход хялбар байдлаар боловсруулах нь зүйтэй.

## 3. Хувь хүний нууц мэдээлэлд анхаарах

Шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэхдээ нууцалсан мэдээлэл, холбогдох этгээдийн хувь хүний нууцтай холбоотой асуудалд онцгой анхаарал хандуулж, бэлтгэх шаардлагатай.

## 4. Шүүхийн шийдвэрийн хураангуйг тараах тоо ширхэгт анхаарах

Олон нийтийн анхаарал татсан хэрэгт сэтгүүлчдээс шүүхийн шийдвэрийн хураангуйг хэсэг хэсгээр нь олон тоо ширхэгээр авахыг хүсдэг. Энэ нь сэтгүүлчид тухайн нийтлэлийг хувааж бичээд, хамт нийтлүүлэх зорилготой байдагтай нь холбоотой. Иймд аль болох боломжийн хэрээр сэтгүүлчдийн хүсэлтэд нийцүүлэх шаардлагатай.

## 5. Шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх боломжгүй тохиолдолд анхаарах зүйл

Шүүхийн шийдвэрийг танилцуулахаас өмнөхөн сэтгүүлчдээс хүсэлт гаргасан бөгөөд шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх цаг хугацааны боломжгүй байх тохиолдолд шүүхийн шийдвэрийн хуулбар хувь дээр хураангуйлах хэсэгт хамаарч болох хэсэгт нь тодруулах зураас зурж өгөх зэрэг нь сэтгүүлчдэд тухайн шийдвэрийг ойлгоход дэмжлэг болдог.

### 1.3. Шүүхийн шийдвэрийн хураангуйг тараах, хүргүүлэх

Шүүхийн шийдвэрийн хураангуйг шүүхийн шийдвэрийг танилцуулсны дараа Олон нийттэй харилцах хэлтсээс сэтгүүлчдэд тараах нь зохимжтой.

Мөн шүүхийн шийдвэрийн хураангуй нь шуурхай хугацаанд хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангахын тулд гаргасан зүйл боловч эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагаанд оролцсон хэргийн оролцогчдын хувьд шүүхийн шийдвэрийн хураангуйг хүсэх тохиолдол гардаг. Ийм тохиолдолд шүүгч болон шүүх бүрэлдэхүүний саналыг авсны дараа шүүхийн захиргааны байгууллагын ажлыг хөнгөвчилж, тухайн хэргийн оролцогчид хэвлэл мэдээллийн байгууллагад өгсөн шүүхийн шийдвэрийн хураангуйг өгөх нь тохиромжтой байдаг. Ингэхдээ тухайн шүүхийн шийдвэрийн хураангуй нь шүүхээс олон

нийтийг мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд боловсруулсан шүүхийн бусад албан ёсны баримт бичигтэй адил шинж чанартай зүйл бөгөөд шүүхийн албан ёсны баримт бичгийг ил болгож буйтай адил зохицуулалт хамаарна гэдгийг анхаарах хэрэгтэй.

#### **1.4. Бусад шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэхэд анхаарах зүйл**

Өсвөр насны хүүхдийн хэргийг шийдвэрлэж буй шүүн таслах ажиллагаа нь нээлттэй явагддаггүй бөгөөд зарчмын хувьд тухайн хэргийн шүүхийн шийдвэрийн хувийг хэвлэл мэдээллийн байгууллагад өгдөггүй боловч олон нийтийн анхаарлыг татсан хэргийн тухайд хэвлэл мэдээллийн байгууллагаас шүүхийн шийдвэрийн хураангуйг хүссэн тохиолдолд онцгой тохиолдол хэмээн үзэж, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг төдийгүй шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэж, хэвлэл мэдээллийн байгууллагад өгөх тохиолдол бий. Энэ нь ялангуяа өсвөр насны хүүхдийн үйлдсэн олны анхаарлыг татсан хэргийн хувьд шүүх байгууллагад нийгэмд тайлбарлах үүрэг хариуцлагыг хүлээлгэж, гэр бүлийн шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулахгүй байх зорилгоор тодорхой хэмжээнд, шүүхийн шийдвэрийн нарийвчилсан агуулгыг хурдан хугацаанд хэвлэл мэдээллийн байгууллагад танилцуулж буй хэрэг юм.

Мөн тухайн хэргийн шүүхийн шийдвэрийг холбогдох этгээдэд хэдийд танилцуулсан зэрэг нь тодорхой мэдэгдэхгүй байх зэрэг нээлттэй явагдсан шүүн таслах ажиллагаанаас ялгаатай байх тохиолдол цөөнгүй байдаг тул хэвлэл мэдээллийн байгууллагад шүүхийн шийдвэрийн хураангуйг өгөхдөө шүүгч болон шүүх бүрэлдэхүүнтэй маш сайн зөвлөлдөх шаардлагатай.

Түүнчлэн өсвөр насны хүүхдийн үйлдсэн хэргийн хохирогчийн талаас бидний зүгээс шүүхийн шийдвэртэй танилцахын өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүхийн шийдвэр цацагдсанд гомдолтой байна гэх тохиолдол гардаг. Энэ төрлийн гомдлыг шийдвэрлэх нэг арга нь хохирогч болон түүний өмгөөлөгчийг шүүн таслах ажиллагаа дуусгавар болсны дараа шууд шүүхийн шийдвэрийн хураангуйг авч явах эсхүл авахаар ирэхийг мэдэгдэх, хэвлэл мэдээллийн байгууллагад өгснөөс илүү нарийвчилсан агуулга бүхий шүүхийн шийдвэрийн хураангуйг тусад нь бэлтгэж, хохирогч талд өгөх нь тохиромжтойг анхаарах нь зүйтэй.

### **Хоёр. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 22.11 дэх хэсэгт холбогдох хуулийн зохицуулалт**

#### **2.1. Иргэний хэргийн шүүх (захиргааны хэргийн дагнасан шүүх байхгүй бөгөөд иргэний хэргийн шүүх нь захиргааны хэргийг харьяалан шийдвэрлэдэг)**

Тус улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5-р бүлэгт шүүхийн шийдвэрийг хэрхэн гаргах талаарх асуудлыг зохицуулсан. Тус хуулийн

250-р зүйлд “Шүүхийн шийдвэр нь танилцуулснаар хүчин төгөлдөр болно”

251.1-р зүйлд “Шүүхийн шийдвэрийг шүүх хуралдааныг хаасан өдрөөс хойш 2 сарын дотор гаргаж, танилцуулна. Гэвч хэргийн ээдрээ төвөгтэй байдал болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан энэхүү хугацааг баримтлахгүй байж болно”

251.2-р зүйлд “Шүүхийн шийдвэрийг талуудыг шүүх хуралдааны танхимд хүрэлцэн ирээгүй тохиолдолд ч танилцуулж болно”

252-р зүйлд “Шүүхийн шийдвэрийг танилцуулахдаа шүүхийн шийдвэрийн эх хувьд үндэслэнэ”

253.1-р зүйлд “Шүүхийн шийдвэр нь дараах бүтэцтэй байна. Үүнд

1. Тогтоох хэсэг
2. Тодорхойлох хэсэг буюу талуудын тайлбар болон хэргийн үйл баримтын талаарх танилцуулга
3. Үндэслэл
4. Шүүх хуралдаан хаасан өдөр
5. Талууд болон тэдний хууль ёсны төлөөлөгчид
6. Шүүхийн нэр”

253.2-р зүйлд “Хэргийн үйл баримтыг тусгахдаа нэхэмжлэлийн шаардлагыг тодорхой болгосон, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг үнэн зөв болсон гэдгийг харуулахад шаардлагатай тайлбарыг дурдах шаардлагатай” зэргээр зохицуулжээ.

Дээрхээс үзэхэд тус улсын иргэний хэргийн шүүхийн шүүгч нь өөрийн шийдвэрийг шүүх хуралдаан дууссанаас хойш дор хаяж 2 сарын дараа гаргаж, танилцуулдаг байна. Энэ нь шүүх хуралдаан дууссаны дараа шууд шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг танилцуулдаг манай улсын хууль зүйн зохицуулалтаас ялгаатай юм. Мөн шүүхийн шийдвэртээ үндэслэх хэсгийг заавал тусгахаар хуульчилсан нь талуудад шүүхийн шийдвэрийг тайлбарлаж буй нэг хэлбэр гэж үздэг. Харин манай улсын Шүүхийн тухай хуульд шинээр хуульчилсан шүүхийн шийдвэрийг бичгээр танилцуулах тухай зохицуулалт байхгүй юм.

## **2.2. Эрүүгийн хэргийн шүүх**

Тус улсын Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5-р бүлэгт шүүхийн шийдвэрийн талаар зохицуулсан бөгөөд 44.1-р зүйлд “Шүүгч шийдвэртээ үндэслэлээ заасан байх ёстой”, 44.2-р зүйлд “давж заалдах болон хяналтын гомдол гаргахгүйгээр зохицуулсан шийдвэр, захирамжид үндэслэл заах шаардлагагүй. Гэвч тус хуулийн 428.2-т заасны дагуу эсэргүүцэл буюу гомдол гаргах боломжтой шийдвэрийн хувьд энэхүү зохицуулалт хамаарахгүй” гэж заажээ.

Эндээс үзэхэд шүүгч шийдвэртээ үндэслэлээ заах нь талуудад шийдвэрээ тайлбарлаж буйд тооцогддог байна. Харин манай улсын Шүүхийн тухай хуульд шинээр хуульчилсан шүүхийн шийдвэрийг бичгээр танилцуулах тухай зохицуулалт байхгүй юм.

Мөн тус улсын Шүүхийн тухай хуульд манай улсын хуулийн 22.10 болон 11-тэй ижил төстэй зохицуулалт байхгүй байна.

### **Канадын шүүхийн шийдвэр танилцуулах тухай:**

Канадын шүүх нь хэрэг хянан шийдвэрлэхдээ хуульд заасан үндэслэл болон тухайн хэрэгтэй ижил төрлийн кейсийг бүс нутагт хэрхэн шийдвэрлэж байсан туршлага, мөн сэдвийн хүрээний зохиол ном товхимлоос эш татаж эдгээрийг харгалзан үзэж шийдвэрээ гаргадаг байна.

Шийдвэрийг танилцуулахдаа Канадын дээд шүүхийн [https://decisions.scc-csc.ca/scc-csc/scc-csc/en/nav\\_date.do](https://decisions.scc-csc.ca/scc-csc/scc-csc/en/nav_date.do) холбоосоор шийдвэр гарсан оноор нийтэд нээлттэй жагсаасан байна. Энэ нь олон нийтэд шүүхийн шийдвэртэй холбоотой асуудалд эш татах, өөрийгөө өмгөөлөх боломж олгодог.

Жишээ нь: Доорх кейс нь Хүүхэд хамгааллын газраас хүүхдийн хууль ёсны асран халамжлагчийг тогтоох тухай маргаан юм. Тус хэргийг давж заалдах шатны шүүхэд хэрхэн шийдвэрлэсэн тухай дээрх сайтад байршуулсан байна. Үүнд хэд хэдэн шийдвэр гаргах үндэслэлүүдийг жагсаажээ.

1. **Эш татсан тохиолдлууд:** Өмнө нь ижил төстэй хэргүүд дээр хэрхэн шийдвэрлэж байсан талаар эш татсан шүүхийн шийдвэрүүд.

Хэрэглэсэн:

- Ван де Перре Эдвардсын эсрэг
- Балевын эсрэг Хүүхдийн хуульч, 2018 ХЗХ 16, [2018] 1 S.C.R. 398;
- Томсон Томсоны эсрэг,
- Хатан хаан Люпиенийн эсрэг,
- Фрейм Смитийн эсрэг, [1987] 2 S.C.R. 99;
- А.С.-ийн эсрэг Манитоба (Хүүхэд ба гэр бүлийн үйлчилгээний захирал),
- Торонто хотын Католик Хүүхдийн Тусламжийн Нийгэмлэгийн эсрэг М.(С.), гэх мэтээр хэргүүдээс эш татсан тохиолдлуудыг цувруулан оруулсан.

## 2. Иш татсан дүрэм, журам

- Канадын эрх, эрх чөлөөний дүрэм, s. 7.
- Хүүхэд хамгааллын тухай хууль, R.S.P.E.I. 1988, с. С 5.1, ss. 1(s), 2(2), 27, 29, 30, 36, 37, 38(2)(c), (d), (e), 41.
- Хүүхэд, залуучууд, гэр бүлийг сайжруулах тухай хууль, R.S.A. 2000, с. С 12, s. 2(1).
- Хүүхдийн тухай хууль, R.S.P.E.I. 1988, с С 6.1, s. 33.
- Гэр бүл салалтын тухай хууль, R.S.C. 1985, с. 3 (2-р нэмэлт), s. 16(3).
- Гэр бүлийн тухай хууль, S.A. 2003, с. F 4.5, s. 18.

## 3. Иш татсан зохиол

- Бала, Николас, Жэйн Томсон нар. Хүүхдийн халамжийн тохиолдлын шинжээчийн нотлох баримт ба үнэлгээ, Хатан хааны хуулийн судалгааны цуврал № 63. Кингстон: Хатан хааны их сургууль, 2015.
- Бала, Николас. "Канадын гэр бүл салалтын тухай хуулийг шинэ мянганд оруулах нь: Хүүхдэд чиглэсэн эцэг эхийн тухай хуулийг батлах нь" (2015), 40 Queen's L.J. 425.
- Шлоссер, М.Жойс. "Хүүхэд төвтэй гуравдагч этгээдийн маргаан: Эцэг эхийн эрх, хүүхдийн дээд ашиг сонирхлын эсрэг" (1984), 22 Альб. Л. Илчлэлт 394.
- Салливан, Рут. Салливан дүрмийн барилгын тухай, 6-р хэвлэл. Маркхам, Онт.: LexisNexis, 2014.
- Вилтон, Анн, Гари С. Жозеф, Тара Трэйн нар. Канад дахь эцэг эхийн хууль ба практик, боть. 1. Торонто: Thomson Reuters, 1992 (сул навч 2022 оны 4-р сард шинэчлэгдсэн, хувилбар 2) ... гэх мэтээр шийдвэрийн үндэслэлүүдийг оруулсан байна.

- ❖ <https://www.canlii.org/en/on/onca/doc/1965/1965canlii251/1965canlii251.html?searchUrl=AAAAAQZSW50cm9kdWNIIGNvdXJ0IGRIY2IzaW9ucwAAAAAB&resultIndex=1>
- ❖ <https://library.law.utoronto.ca/step-2-primary-sources-law-canadian-case-law-0>
- ❖ [https://wislawjournal.com/category/case-digests/?qclid=Cj0KCQjw4uaUBhC8ARIsANUuDjUiw4TbYGgf\\_4PWXDyLma0SVZYktyOwDUOLTJhIdTZaqqCKUARIIK8aAgp9EALw\\_wcB](https://wislawjournal.com/category/case-digests/?qclid=Cj0KCQjw4uaUBhC8ARIsANUuDjUiw4TbYGgf_4PWXDyLma0SVZYktyOwDUOLTJhIdTZaqqCKUARIIK8aAgp9EALw_wcB)
- ❖ [https://decisions.scc-csc.ca/scc-csc/scc-csc/en/nav\\_date.do](https://decisions.scc-csc.ca/scc-csc/scc-csc/en/nav_date.do)

## Австрали

Австрали улсын шүүх нь гаргасан шийдвэрээ тухай бүр нь талуудад танилцуулдаг бөгөөд Шүүхийн шийдвэрийн хуулбарыг Канберра дахь оффисоос шууд авах боломжтой бөгөөд талууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд үнэ төлбөргүй өгдөг. Нэмэлт хуулбарыг 2012 оны Австралийн Дээд Шүүхийн (Төлбөр) журамд заасны дагуу Канберра, Мельбурн, Сидней дэх Бүртгэлийн газрын оффисуудад талууд болон олон нийт худалдан авч болно. Бусад хотод шүүх хуралдааны үеэр шийдвэр гаргасан тохиолдолд энэ үйлчилгээг үзүүлдэг.



Шүүхийн шийдвэрийг хүргүүлсний дараа <http://eresources.hcourt.gov.au/> цахим хуудаснаас үзэх боломжтой. Цахим хуудсанд байршуулахдаа нэхэмжлэгчийг тодорхой кодоор кодолж сайтад байршуулдаг. Ингэхдээ хэргийн товч утга болон шүүх хуралдааны явц, мөн шийдвэрлэсэн хуулийн заалт зэрэг товч мэдээллийг л олон нийтэд үзүүлдэг байна. Жишээ нь: Гэр бүлийн тухай хууль 1975 (Cth), ss 4AA, 90SM ...

- ❖ <https://www.austlii.edu.au/translate/goog/database-all.html? x tr sl=auto& x tr tl=mn& x tr hl=en& x tr pto=wapp& x tr sch=http>
- ❖ <https://eresources.hcourt.gov.au/>

## Герман

Германы шүүх нь шийдвэрээ албан байдлаар гаргаж шүүх хуралдааны үед танилцуулдаг. Энэ нь олон нийт уншихад хэт ойлгомжгүй байдаг бөгөөд шийдвэрийг хуульч, өмгөөлөгчөөр дамжуулан тайлбарлуулдаг. Үүнтэй холбоотой шүүхийн шийдвэрүүдийг иргэдэд тайлбарлан ойлгомжтой байдлаар хүргэдэг хуульч, болон сайтууд байдаг. Иргэд эдгээрт төлбөр төлж үйлчилгээ авдаг байна.

Сайтад тавигдсан мэдээллийг жишээгээр үзүүлэв:



## 734-р хэсэг

Шүүхийн шийдвэрийн эх хувь дээр хуулбарласан тухай тэмдэглэл

1 Шүүхийн шийдвэрийн эх хувийг гаргахын өмнө аль талд, хэдэн цагт гаргасан тухай тэмдэглэл хийх шаардлагатай. 2 Хэргийн материалыг цахим хэлбэрээр хөтөлж байгаа бол тэмдэглэлийг тусдаа цахим баримт бичигт бүртгэнэ. 3 Баримт бичиг нь шүүхийн шийдвэртэй салшгүй холбоотой байх ёстой.

## 310-р хэсэг

### Шүүхийн шийдвэр гаргах эцсийн хугацаа

(1) Шүүхийн шийдвэрийг аман сонсгол хаагдсан өдөр эсвэл нэн даруй өдөр товлон зарлана. 2 Хэрэв чухал шалтгаанууд, ялангуяа асуудлын цар хүрээ, хүндрэл зэргээс шалтгаалан хойшлуулбал зөвхөн гурван долоо хоногоос илүүгүй хугацаагаар сунгана.

(2) Шүүхийн шийдвэрийг аман хэлэлцүүлгийг хаах өдөр зарлаагүй бол түүнийг зарлахдаа шийдвэрийг бүрэн эхээр нь боловсруулсан байх ёстой.

(3) 1 307 ба 331 (3)-д заасны дагуу амаар сонсголгүйгээр гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрч, өргөдлөөр шийдвэрлэсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийг танилцуулах замаар солигдоно. 2 Өргөдөл шийдвэрийн эсрэг гаргасан эсэргүүцлийг үгүйсгэсэн шийдвэрт мөн адил хамаарна ( 341 -р зүйлийн 2-т).

<https://www.npridik.de/warum-es-sinnvoll-ist-gerichtsentscheidungen-auch-visuell-aufzubereiten/> кейс

Герман улсын шүүхийн үндсэн хууль: <https://dejure.org/gesetze/GVG> GVG (Шүүхийн Үндсэн хуулийн хууль)

Герман улсын үндсэн хууль: <https://dejure.org/gesetze/GG>

Герман улсын хуулийн сайт: <https://dejure.org/>

Герман улсын шүүхийн шийдвэрүүдийн цахим сан: <https://www.sozialgerichtsbarkeit.de/entscheidungen>

### Канадын шүүхийн шийдвэр танилцуулах тухай:

Канадын шүүх нь хэрэг хянан шийдвэрлэхдээ хуульд заасан үндэслэл болон тухайн хэрэгтэй ижил төрлийн кейсийг бүс нутагт хэрхэн шийдвэрлэж байсан туршлага, мөн сэдвийн хүрээний зохиол ном товхимлоос эш татаж эдгээрийг харгалзан үзэж шийдвэрээ гаргадаг байна.

Шийдвэрийг танилцуулахдаа Канадын дээд шүүхийн [https://decisions.scc-csc.ca/scc-csc/scc-csc/en/nav\\_date.do](https://decisions.scc-csc.ca/scc-csc/scc-csc/en/nav_date.do) холбоосоор шийдвэр гарсан оноор нийтэд нээлттэй жагсаасан байна. Энэ нь олон нийтэд шүүхийн шийдвэртэй холбоотой асуудалд эш татах, өөрийгөө өмгөөлөх боломж олгодог.

Жишээ нь: Доорх кейс нь Хүүхэд хамгааллын газраас хүүхдийн хууль ёсны асран халамжлагчийг тогтоох тухай маргаан юм. Тус хэргийг давж заалдах шатны шүүхэд хэрхэн шийдвэрлэсэн тухай дээрх сайтад байршуулсан байна. Үүнд хэд хэдэн шийдвэр гаргах үндэслэлүүдийг жагсаажээ.

4. **Эш татсан тохиолдлууд:** Өмнө нь ижил төстэй хэргүүд дээр хэрхэн шийдвэрлэж байсан талаар эш татсан шүүхийн шийдвэрүүд.

Хэрэглэсэн:

- Ван де Перре Эдвардсын эсрэг
- Балевын эсрэг Хүүхдийн хуульч, 2018 ХЗХ 16, [2018] 1 S.C.R. 398;
- Томсон Томсоны эсрэг,
- Хатан хаан Люпиенийн эсрэг,
- Фрейм Смитийн эсрэг, [1987] 2 S.C.R. 99;

- А.С.-ийн эсрэг Манитоба (Хүүхэд ба гэр бүлийн үйлчилгээний захирал),
- Торонто хотын Католик Хүүхдийн Тусламжийн Нийгэмлэгийн эсрэг М.(С.), гэх мэтээр хэргүүдээс эш татсан тохиолдлуудыг цувруулан оруулсан.

#### 5. Иш татсан дүрэм, журам

- Канадын эрх, эрх чөлөөний дүрэм, s. 7.
- Хүүхэд хамгааллын тухай хууль, R.S.P.E.I. 1988, с. С 5.1, ss. 1(s), 2(2), 27, 29, 30, 36, 37, 38(2)(c), (d), (e), 41.
- Хүүхэд, залуучууд, гэр бүлийг сайжруулах тухай хууль, R.S.A. 2000, с. С 12, s. 2(1).
- Хүүхдийн тухай хууль, R.S.P.E.I. 1988, с С 6.1, s. 33.
- Гэр бүл салалтын тухай хууль, R.S.C. 1985, с. 3 (2-р нэмэлт), s. 16(3).
- Гэр бүлийн тухай хууль, S.A. 2003, с. F 4.5, s. 18.

#### 6. Иш татсан зохиол

- Бала, Николас, Жэйн Томсон нар. Хүүхдийн халамжийн тохиолдлын шинжээчийн нотлох баримт ба үнэлгээ, Хатан хааны хуулийн судалгааны цуврал № 63. Кингстон: Хатан хааны их сургууль, 2015.
- Бала, Николас. "Канадын гэр бүл салалтын тухай хуулийг шинэ мянганд оруулах нь: Хүүхдэд чиглэсэн эцэг эхийн тухай хуулийг батлах нь" (2015), 40 Queen's L.J. 425.
- Шлоссер, М.Жойс. "Хүүхэд төвтэй гуравдагч этгээдийн маргаан: Эцэг эхийн эрх, хүүхдийн дээд ашиг сонирхлын эсрэг" (1984), 22 Альб. Л. Илчлэлт 394.
- Салливан, Рут. Салливан дүрмийн барилгын тухай, 6-р хэвлэл. Маркхам, Онт.: LexisNexis, 2014.
- Вилтон, Анн, Гари С. Жозеф, Тара Трэйн нар. Канад дахь эцэг эхийн хууль ба практик, боть. 1. Торонто: Thomson Reuters, 1992 (сул навч 2022 оны 4-р сард шинэчлэгдсэн, хувилбар 2) ... гэх мэтээр шийдвэрийн үндэслэлүүдийг оруулсан байна.

- ❖ <https://www.canlii.org/en/on/onca/doc/1965/1965canlii251/1965canlii251.html?searchUrlHash=AAAAAQZSW50cm9kdWNlIGNvdXJ0IGRIY2lzaW9ucwAAAAAB&resultIndex=1>
- ❖ <https://library.law.utoronto.ca/step-2-primary-sources-law-canadian-case-law-0>
- ❖ [https://wislawjournal.com/category/case-digests/?gclid=Cj0KCQjw4uaUBhC8ARIsANUuDjUiw4TbYGgf\\_4PWXDyLma0SVZYktyOwDUOLTJhldTZaqqCKUARlIK8aAgp9EALw\\_wcB](https://wislawjournal.com/category/case-digests/?gclid=Cj0KCQjw4uaUBhC8ARIsANUuDjUiw4TbYGgf_4PWXDyLma0SVZYktyOwDUOLTJhldTZaqqCKUARlIK8aAgp9EALw_wcB)
- ❖ [https://decisions.scc-csc.ca/scc-csc/scc-csc/en/nav\\_date.do](https://decisions.scc-csc.ca/scc-csc/scc-csc/en/nav_date.do)

#### Австрали

Австрали улсын шүүх нь гаргасан шийдвэрээ тухай бүр нь талуудад танилцуулдаг бөгөөд Шүүхийн шийдвэрийн хуулбарыг Канберра дахь оффисоос шууд авах боломжтой бөгөөд талууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд үнэ төлбөргүй өгдөг. Нэмэлт хуулбарыг 2012 оны Австралийн Дээд Шүүхийн (Төлбөр) журамд заасны дагуу Канберра, Мельбурн, Сидней дэх Бүртгэлийн газрын оффисуудад талууд болон олон нийт худалдан авч болно. Бусад хотод шүүх хуралдааны үеэр шийдвэр гаргасан тохиолдолд энэ үйлчилгээг үзүүлдэг.

Шүүхийн шийдвэрийг хүргүүлсний дараа <http://eresources.hcourt.gov.au/> цахим хуудаснаас үзэх боломжтой. Цахим хуудсанд байршуулахдаа нэхэмжлэгчийг тодорхой кодоор кодолж сайтад байршуулдаг. Ингэхдээ хэргийн товч утга болон шүүх хуралдааны явц, мөн шийдвэрлэсэн хуулийн заалт зэрэг товч мэдээллийг л олон нийтэд үзүүлдэг байна. Жишээ нь: Гэр бүлийн тухай хууль 1975 (Cth), ss 4AA, 90SM ...




- ❖ <https://www.austlii-edu-au.translate.goog/database-all.html? x tr sl=auto& x tr tl=mn& x tr hl=en& x tr pto=wapp& x tr sch=http>
- ❖ <https://eresources.hcourt.gov.au/>

## Герман

Германы шүүх нь шийдвэрээ албан байдлаар гаргаж шүүх хуралдааны үед танилцуулдаг. Энэ нь олон нийт уншихад хэт ойлгомжгүй байдаг бөгөөд шийдвэрийг хуульч, өмгөөлөгчөөр дамжуулан тайлбарлуулдаг. Үүнтэй холбоотой шүүхийн шийдвэрүүдийг иргэдэд тайлбарлан ойлгомжтой байдлаар хүргэдэг хуульч, болон сайтууд байдаг. Иргэд эдгээрт төлбөр төлж үйлчилгээ авдаг байна.

Сайтад тавигдсан мэдээллийг жишээгээр үзүүлэв:



## 734-р хэсэг

Шүүхийн шийдвэрийн эх хувь дээр хуулбарласан тухай тэмдэглэл

1 Шүүхийн шийдвэрийн эх хувийг гаргахын өмнө аль талд, хэдэн цагт гаргасан тухай тэмдэглэл хийх шаардлагатай. 2 Хэргийн материалыг цахим хэлбэрээр хөтөлж байгаа бол тэмдэглэлийг тусдаа цахим баримт бичигт бүртгэнэ. 3 Баримт бичиг нь шүүхийн шийдвэртэй салшгүй холбоотой байх ёстой.

## 310-р хэсэг

Шүүхийн шийдвэр гаргах эцсийн хугацаа

(1) Шүүхийн шийдвэрийг аман сонсгол хаагдсан өдөр эсвэл нэн даруй өдөр товлон зарлана. 2 Хэрэв чухал шалтгаанууд, ялангуяа асуудлын цар хүрээ, хүндрэл зэргээс шалтгаалан хойшлуулбал зөвхөн гурван долоо хоногоос илүүгүй хугацаагаар сунгана.

(2) Шүүхийн шийдвэрийг аман хэлэлцүүлгийг хаах өдөр зарлаагүй бол түүнийг зарлахдаа шийдвэрийг бүрэн эхээр нь боловсруулсан байх ёстой.

(3) 1 307 ба 331 (3)-д заасны дагуу амаар сонсголгүйгээр гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрч, өргөдлөөр шийдвэрлэсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийг танилцуулах замаар солигдоно. 2 Өргөдөл шийдвэрийн эсрэг гаргасан эсэргүүцлийг үгүйсгэсэн шийдвэрт мөн адил хамаарна ( 341 -р зүйлийн 2-т).

<https://www.npridik.de/warum-es-sinnvoll-ist-gerichtsentscheidungen-auch-visuell-aufzubereiten/> кейс

Герман улсын шүүхийн үндсэн хууль: <https://dejure.org/gesetze/GVG> GVG (Шүүхийн Үндсэн хуулийн хууль)

Герман улсын үндсэн хууль: <https://dejure.org/gesetze/GG>

Герман улсын хуулийн сайт: <https://dejure.org/>

Герман улсын шүүхийн шийдвэрүүдийн цахим сан: <https://www.sozialgerichtsbarkeit.de/entscheidungen>

## Солонгос улс

1. [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=47509&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=47509&lang=ENG)
2. <https://law.go.kr/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=public+imformation&x=0&y=0>

Хуулийн мэдээллийн сайтад:

33 дүгээр зүйл Шүүх хуралдааны шийдвэр гаргалтын тухай

Шүүх хуралдаанд шууд амаар мэтгэлцэж эцсийн шийдвэрийг гаргана. Үндсэн хуулийн шүүхийн дарга шаардлагатай гэвэл амаар мэтгэлцэх, эцсийн шийдвэрийг гаргахдаа шүүх хуралдааны танхимаас гадуур хийж болно.

34 дүгээр зүйл (Шүүхийг олон нийтэд нээлттэй болгох)

Шүүхийн мэтгэлцээн, шүүхийн шийдвэрийн танилцуулга нь олон нийтэд нээлттэй байх ёстой: Аливаа бичгээр хянан хэлэлцэх болон Шүүхийн зөвлөлдөх хурал олон нийтэд нээлттэй байж болохгүй.

Шүүхийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтыг Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн нөхцөл байдлаас хамааруулж хэрэглэнэ.

## Нидерланд улс

1. <https://www.rechtspraak.nl/Organisatie-en-contact/Rechtspraak-in-Nederland-> Нидерланд улсын Шүүхийн Ерөнхий зөвлөлийн сайтад шүүхийн сэтгүүл /жилд 4 удаа/-ийг дижитал хэлбэрээр үзэж болохоос гадна тус сэтгүүлийг үнэ төлбөргүй захиалах боломжтой. Захиалга хийхийн тулд нэр болон хаягаа бүртгүүлэх хэрэгтэй.

Мөн сайтдаа мэдээллийн хуудсыг ажиллуулдаг. Түүн дотор тус долоо хоногийн хамгийн чухал шүүхийн практик мэдээллийг олон нийтэд танилцуулдаг.

Олон нийтэд зориулсан сэтгүүлээс гадна шүүхийн үйл ажиллагаанд мэргэжлийн түвшинд оролцдог хүмүүст зориулсан шүүхийн практикийн сэтгүүл гаргадаг.

Нидерландын шүүхийн байгууллагын тухай хуулийн линк <http://www.dutchcivillaw.com/judiciaryact.htm> - 4 дүгээр зүйл Олон нийтийн өмнө сонсгол хийх

- 1.Хуульд өөрөөр заагаагүй бол шүүхийн шийдвэрийг хүчингүйд тооцож, нээлттэй явуулах ёстой.

- 2.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдааны явцад шалгалтыг бүхэлд нь болон хэсэгчлэн хаалттай явуулж болно. Шалтгааныг шүүх хуралдааны албан ёсны тэмдэглэлд тусгасан байх ёстой.

13 дугаар зүйл (Бусад мэдээллийн нууцлал)

14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн захиргааны ажилтан, шүүхийн хуульчийн туслах, дадлагажигч шүүгчид, Улсын дээд шүүхийн нарийн бичгийн дарга/бүртгэгч, орлогч, түүний үүрэг гүйцэтгэгч, шүүхийн захиргааны ажилтан, шүүхийн хөндлөнгийн нарийн бичгийн дарга/бүртгэлийн ажилтан 4 ажлын явцад тэдний анхаарлыг татсан, нууцын шинж чанартай гэдгийг мэдэж байгаа буюу мэдэхээр хүлээгдэж буй мэдээллийг хууль ёсны дагуу мэдэгдэх үүрэгтэйгээс бусад тохиолдолд задруулахыг хориглоно.

### **Сингапур улс**

1. <https://www.lawnet.sg/lawnet/web/lawnet/free-resources?fbclid=IwAR2BJ8g3v2d2FH0xEU0nx4UQs6jznGQjob3H-ONrg8GxHCR6ZywU18-60-k-LawNet>-ийн Эрх зүйн судалгааны модуль нь 1997 оны 1-р сарын 1-ээс эхлэн Сингапурын Ерөнхий прокурорын танхимаас гаргасан хууль тогтоомж болон хэргийн тойм, Дээд шүүхийн шийдвэрийн тайлбар, тайлангийн хувилбарууд болон Улсын дээд болон мужийн шүүхийн өмнөх шүүхийн шийдвэрийн бүрэн архивыг зөвхөн LawNet-ийн захиалагчдад л үзэх боломжтой.

Хамгийн сүүлийн үеийн Сингапурын шийдвэрүүд дараах 3 төрөлд хуваан нийтэлдэг. Үүнд:

- Дээд шүүхийн шийдвэрүүд гэсэн хэсэгт Сингапурын Дээд шүүхээс сүүлийн гурван сарын хугацаанд гаргасан хамгийн сүүлийн үеийн шийдвэрүүдийг багтаасан.
- Мужийн шүүхийн шийдвэрүүд-Тус хэсэгт Сингапурын муж улсын шүүхүүдийн сүүлийн гурван сарын хамгийн сүүлийн үеийн шийдвэрүүдийг багтаасан.
- Гэр бүлийн шүүх болон насанд хүрээгүй хүмүүсийн шүүхийн шийдвэрүүд-Тус хэсэгт сүүлийн гурван сарын хугацаанд Сингапурын гэр бүлийн шүүхээс гаргасан хамгийн сүүлийн үеийн шийдвэрүүдийг багтаасан.

### **Цахим шүүх ажиллагаа**

2. <https://www.elitigation.sg/layouts/IELS/HomePage/Pages/Home.aspx>-Шүүхийн нэгдсэн цахим систем (eLitigation) нь 2013 онд хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ нь Сингапурын шүүхийн цахим мэдүүлгийн системийн (EFS) сайжруулсан хувилбар юм. eLitigation нь хуулийн фирмүүд болон шүүхийн хэрэглэгчдэд шүүхийн баримт бичгийг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх нэгдсэн платформоор хангаж, шүүх ажиллагааны явцад хэргийн материалыг идэвхтэй удирдах боломжийг олгодог. Нэмж дурдахад eLitigation нь ном хайх, хэргийн файлуудыг шалгах боломжийг олгодог.

## Сингапур улсын хуулийн тоймын сайт

3. <https://www.singaporelawwatch.sg/> -Шийдвэр, шийдвэрийг шийдвэрлэсэн огнооны дагуу бүх шийдвэрийг олох боломжтой. 2000 оны Дээд шүүхийн шийдвэр, 2018 оноос хойших IPOS болон PDPC шийдвэрүүд SLW дээр байнга архивлагддаг. Хэрэв SLW дээр шүүлт эсвэл шийдвэр байхгүй бол түүнийг LawNet дээрээс олж болно эсвэл нийтлэх шатандаа байгааг илэрхийлнэ.
4. <https://www.judiciary.gov.sg/>-Сингапур улсын шүүхүүдийн үүрэг, бүтэц, алсын хараа, эрхэм зорилго, түүх, статистик, олон улсын хамтын ажиллагаа зэрэг мэдээллүүд байрших сайт.

Тус сайтаас Сингапурын шүүх болон бусад холбогдох материалаас гаргасан бичгээр гаргасан шийдвэрүүдийг олох боломжтой.

Мөн Шүүхийн шийдвэрт хөндлөнгийн дүгнэлт өгч, бичсэн нийтлэлээ олон нийтэд хүргэх, тухайн мэдээлэл шаардлагатай хүн бүхэнд хүрч, мэдээллийг PDF хэлбэрээр авах бүрэн боломжтой.

Сингапур улсын хуулийн тойм сайтад нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг цахим орчинд facebook, twitter, email-ээр бусдад түгээх боломжтой.

5. <https://www.gov.sg/article/summary-ministerial-statement-review-case-of-parti-liyani-v-public-prosecutor-2020> - Сингапурын Засгийн газрын сайтад улс төрч нартай холбоотой хэргийн шийдвэрийн талаарх мэдээллийг тухай бүрд нь олон нийтэд текстийн хамт видео хэлбэрээр товч танилцуулдаг.
6. <https://www.mha.gov.sg/who-we-are-> Дотоод хэргийн яамны сайтад мөн шүүхийн шийдвэрүүдийн талаар олон нийтэд ойлгомжтой, товч байдлаар мэдээлэлдэг.
7. [https://www.police.gov.sg/Media-Room/News/20220128\\_strn\\_wrngs\\_ised\\_to\\_frmr\\_bsi\\_emp\\_n\\_his\\_acmplce\\_fr\\_s crt\\_prft\\_arngmt\\_lnk\\_d\\_to\\_1mdb\\_rltd\\_invstmt-](https://www.police.gov.sg/Media-Room/News/20220128_strn_wrngs_ised_to_frmr_bsi_emp_n_his_acmplce_fr_s crt_prft_arngmt_lnk_d_to_1mdb_rltd_invstmt-) Цагдаагийн газар зарим шүүхийн шийдвэрийг товч, бичмэл байдлаар хүргэдэг.
8. <https://www.lawnet.com/icrs/welcome-> хэргийн шийдвэрийн хайлтын систем юм. Тус шүүлтүүр нь логик хайлтын тусламжтайгаар богино хугацаанд холбогдох хэргийг олох боломжтой. ICRS хайлтын систем нь тохиолдлын хүчин зүйл болон холбогдох гэмтэл дээр үндэслэн хайлтыг илрүүлдэг.